

Меньерийн өвчнийг (h.81 icd-10) уламжлалт анагаах ухааны эм, засал эмчилгээгээр эмчилсэн: Эмнэлзүйн тохиолдол

Б.Ундармаа¹, Г.Цэрэндулам², У.Оюун-Эрдэнэ³, Ч.Оюунням³
Д.Насанхишиг³, Э.Халиун³, Г.Цэгмэд³, Ю.Оюунбилэг², В.Энхтуяа²

¹АШУУИС.Монгол Анагаах Ухааны Төв Эмнэлэг

²АШУУИС.Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургууль

³АШУУИС.Мэргэжил Дээшлүүлэх Институт

Цахим шуудан: Undarmaa.bayar@mnums.edu.mn Утас: 89118982

Түлхүүр үг:

Толгой эргэх, чих шуугих, сонсгол буурах, уламжлалт анагаах ухаан, зүү эмчилгээ

Товч утга: Меньерийн өвчин нь сонсголын тэнцвэрийн алдагдлаас болж үүсдэг бөгөөд өвчтөнд толгой эргэх, дотор муухай оргих, бөөлжих, чих шуугих зэрэг шинж тэмдгээр илэрдэг өвчин юм. АНУ-ын хүн амд Меньерийн өвчний тархалт 100.000 хүн амд эмэгтэйчүүд 84, эрэгтэйчүүд 56 байсан ба бүс нутгаар авч үзэхэд хүн ам багатай газруудад түгээмэл тохиолдож, өрхийн орлого нэмэгдэх тусам тус өвчний тархалт нэмэгдэж байгаа нь судалгаагаар батлагджээ. **Зорилго:** Меньерийн өвчний үед уламжлалт анагаах ухааны эм, засал эмчилгээний үр дүнг судлах. **Үр дүн:** Эмчлүүлэгч 43 настай эрэгтэй толгой эргэнэ, бөөлжинө, чих шуугина гэсэн зовууртай. 2023 оноос МАУТЭ-т хандаж, нийт 3 удаагийн уламжлалт эм, засал эмчилгээ хийгдэж, толгой эргэх давтамжийн зай холдож, бусад эмнэлзүйн шинж тэмдгүүд сайжирсан байна. **Дүгнэлт:** Меньерийн өвчнийг эмчлэхэд өвчний дахилт хоорондын зайг уртасгах, амьдралын чанарыг дээшлүүлж, эмнэлзүйн шинж тэмдэг мэдэгдэхүйц буурсан нь Уламжлалт анагаах ухааны эм, засал эмчилгээ үр дүнтэй нь харагдаж байна.

Оршил: Хагас цагирган сувгийн эндолимфийн хүүдий дэх шингэний шимэгдэлт саатаж, тэнд агуулагдах шингэний хэмжээ үлэмж ихэссэнтэй холбоотой үүсдэг бөгөөд толгой эргэх хөдлөл гэнэт эхэлж, хэдэн хормоос хэдэн цаг үргэлжилнэ. Өвчний хурц хөдлөлийн дараа явдал тогтворгүйтэх, толгой бага зэрэг эргэх шинж хэдэн өдрийн турш ажиглагдана. Толгой эргэх хөдлөлийн завсрын үеүдэд сонсгол эргэн засрах боловч, цаашдын дахилтын явцад эргэлтгүй дүлийрэх хандлагатай байдаг¹. Судалгаанаас үзэхэд насны хувьд 40-60 насны хүмүүст, эрэгтэй эмэгтэй хүйсийн харьцаа 1:1-2, хавар намрын улиралд ихэвчлэн тохиолддог ба дэлхий дахинд 2050 онд 16%-иар өсөх хандлагатай байна.^{2,3} Удамшил 10-20%, давс, кофе, энергийн ундаа гэх мэт амьдралын буруу хэв маяг, стресс, сэтгэл түгшил, архаг өвчлөлтүүд мигрень зэрэг нь Меньерийн өвчнийг үүсгэх гол шалтгаан болж байна.³

Меньерийн өвчний эмчилгээний гол зорилго нь дахилтат толгой эргэлтийн сэдэрлийг багасгах, хянах явдал юм. Сонсгол буурах, чих шуугих, чих дүүрэх зовууриуд нь толгой эргэлт намжих үед мөн адил сайжрах тохиолдлууд байх боловч,

одоог хүртэл өвчний үр дүнд үүсэх байнгын сонсгол бууралтаас сэргийлэх эмчилгээ байхгүй байсаар байна³.

Орчин үеийн анагаах ухаанд Меньерийн өвчнийг эмчлэхэд мэдрэл дарангуйлагч, дотор муухайралт бөөлжилтийн эсрэг эм, гистамины эсрэг бэлдмэл, тайвшруулах эм зэргийг толгой эргэлтийн үед хэрэглэдэг ба зарим эмчилгээний төрөл нь гаж нөлөө, сонсгол бууралт үүсгэх эрсдэлтэй төдийгүй бүх өвчтөнд ижил үр дүн өгөхгүй байх тохиолдол элбэг.

Меньерийн өвчин /ICD-10 H.81/ эмнэлзүйн шинж тэмдгийг харгалзан Уламжлалт анагаах ухааны Толгойн цагаан судлын өвчин ТММ16.5, Дуутай дүлий ТМJ02.7 оношны толгой эргэх, бөөлжих, чихэнд усны дуу, хэнгэргийн дуу шиг дуу сонстох зэрэг шинж тэмдгүүдтэй дүйцүүлээ^{4,5}.

Эмнэлзүйн тохиолдол: Эмчлүүлэгч 45 настай эрэгтэй. 2019 оноос үе үе толгой эргэх, дотор муухайрах зовуур илэрдэг байсан. 2023 оны 12-р сард ЭМЖЖ ЧХХ эмнэлэгт Электрокохлеографи (ECochG) шинжилгээгээр Меньерийн өвчин оношлогдсон. Тухайн эмчлүүлэгч толгой эргэнэ, зүүн чих шуугина, дотор муухайрч бөөлжинө,

хоолны дуршил муу, артерын даралт ихсэх үед толгой өвдөж, хүзүү хөшнө, бүсэлхий нуруу хэсгээр хөшиж өвдөнө. Толгой эргэх давтамж 1 сард 3-4 удаа хөдөлнө, эргэх үед нүдээ нээж чадахгүй, өдөржин хэвтэнэ гэсэн зовууртай. Хэсэг газрын үзлэгт: Тэнцвэрийн сорилд Ромберг баруун зүүн талд гуйвна. Хуруу хамрын сорил зүүн талд +/-, Өсгий өлмийн сорилд 2 талд +/- байсан бөгөөд 2024 оны 2-р сар, 8-р сар, 2025 оны 2-р сард тус тус МАУТЭ-т 3 удаа хэвтэн эмчилгээ хийлгүүлсэн. Харшил, хорт зуршилгүй. Эрэгтэйчүүдийн үргүйдэл өвчин 7 жилийн өмнө оношлогдсон ба гэрээр 1 жилийн хугацаанд Т.Вестинорм 16 мг 1,0*1 уусан гэнэ. Европ эмийн эмчилгээ 2 удаа хийлгэсэн ч төдийлөн сайжрал илрээгүй байна.

Эмчлүүлэгчид 7 хоногийн турш Уламжлалт анагаах ухааны эм болон бариа засал, монгол төөнө, сэргээн засах эмчилгээ, хануур, шивүүр, рашаан эмчилгээ, зүү эмчилгээг хавсран хийж, эмчилгээний өмнө ба дараа шинжилгээний үзүүлэлтүүд, эмнэлзүйн шинж тэмдгүүдийг харьцуулан үнэлсэн. Эмийн эмчилгээнд Даль-16, Манагчимбу, Мана-10, 3 үрийн тан, Шингүн-5 зэрэг хаван хөөх, тунгалаг цөвийн боловсролтыг сайжруулах, тархины цусан хангамж сайжруулах, мэдрэл тайвшруулах зэрэг тан эмийг сонгож хэрэглэлээ. Зүү эмчилгээнд: ХАУ-ны Толгой эргэх өвчний Хоосон хамшинжийн хүрээнд Бөөрний ин суларсан шинжийн дагуу Хий цусны гүйдлийг сайжруулах, бөөрний тамирыг сайжруулж, чөмгийг нэмэгдүүлэх зарчмаар Fengchi GB20, Hegu LI4, Taichong LV3, Anmian EX-HN22 Yintang EX-HN3 Shuigou GV26, Baihui DU20, Neiguan PC6, Zusanli ST36, Shenmen HT7, Yifeng SJ17, Tiangong SI19, Shuaigu GB8 сүвүүдийг сонгож, зүүг нэмэх аргаар, цахилгаан зүүг RIPP давтамжаар өдөрт 1 удаа 30 минутаар 7 хоног эмчилгээг хийв. Монгол төөнө эмчилгээг хийн бэлчрүүдээр өдөрт 1 удаа 5 хоног хийлээ. Хануур засал эмчилгээнд 2024 оны 2-р сард Жиншүг судас Rami V.saphena parva, 2025 онд Дагза судас Vv.Occeptales судсуудыг хатгаж эмчилгээний үр дүнг тооцлоо.

Цусны ерөнхий шинжилгээ, шээсний шинжилгээ, биохимийн шинжилгээнд өөрчлөлтгүй. 2 талын чамархай ясны КТГ: хамрын хөндийн самалдаг 2 талд хөөнгөтсөн. Хамрын яс хуучин хугаралтай, хэлбэр бага зэрэг алдагдсан. Тархины судасны ангиографи шинжилгээнд өөрчлөлт илрээгүй. 2023 онд хийгдсэн Цэвэр авианы аудиограмм шинжилгээгээр 43 dB буюу дунд зэргийн сонсгол бууралттай байсан ба 2025 оны 3-р сард давтан шинжилгээгээр 38 dB болж хөнгөн зэргийн сонсгол бууралттай болж сайжирсан.

Эмнэлзүйн өөрчлөлт: 2024 оны 02 дугаар сард хийгдсэн эмчилгээний дараа: Толгой эргэх, бөөлжих зовуурь 1 сард 1 удаа болж багассан,

бүсэлхий нуруу хөших зовуурь намдсан. 2024 оны 08 дугаар сард хийгдсэн эмчилгээний дараа: Толгой эргэх, бөөлжих зовуурь 3-4 сард 1 удаа хөдөлсөн. 2024.08-2025.02 сарын хугацаанд 11-р сард 1 удаа зовуурь илэрсэн. 2025 оны 02 дугаар сард хийгдсэн эмчилгээний дараа толгой эргэх, бөөлжих зовуурь одоогоор илрээгүй байна.

Хэлцэмж: Меньерийн өвчин нь шалтгаан тодорхойгүйгээр, дахилтат толгой эргэлт, сонсгол бууралт, чих шуугилт болон чих дүүрэх гэсэн дөрвөн гол шинж тэмдгүүдээр илрэх дотор чихний эмгэг юм. Ихэнх тохиолдолд толгой болон орчны юмс тойрон эргэлдэх маягийн толгой эргэлт 20 минутаас 24 цаг хүртэл үргэлжлэх бөгөөд толгой эргэлттэй хамт дотор муухайрах, бөөлжих шинжүүд хамтдаа илрэх нь бий. Орчин үеийн анагаах ухаанд Меньерийн өвчнийг эмчлэхэд мэдрэл дарангуйлагч, дотор муухайралт бөөлжилтийн эсрэг эм, гистамины эсрэг бэлдмэл, тайвшруулах зэрэг шинж тэмдгийн эмчилгээ 2 удаа хийлгээд зовуурь намдаагүй тул уламжлалт анагаах ухааны эмчилгээний аргыг сонгон хэрэглэх зайлшгүй шаардлага үүссэн.

Монголын уламжлалт анагаах ухаанд Толгойн цагаан судлын өвчин ТММ16.5, Дуутай дүлий ТМЖ02.7 оношны эмнэлзүйн шинж тэмдгүүд дүйцэж, судалгаанд хэрэглэсэн монгол эмийн чадал болон уламжлалт засал эмчилгээнүүд нь үрэвсэл дарах, бодисын солилцоог сайжруулах, цусны эргэлтийг дэмжих, стресс бууруулах, мэдрэл тайвшруулах зэрэг олон талын ашиг тустай болохыг энэ судалгаа харууллаа.

Меньерийн өвчний эмчилгээнд зүү эмчилгээний үр нөлөө, аюулгүй байдал: системчилсэн тойм, мета-анализ судалгаагаар 240 хүнийг санамсаргүй түүврийн аргаар эмийн эмчилгээ болон эм, зүү хавсарсан 2 бүлэгт хувааж эмчилгээ хийсэн. Baihui (GV20), Fengchi (GB20), Tinggong (SI19), Hegu (LI4), Quchi (LI11), Zusanli (ST36), Fenglong (ST40), Taichong (LR3), and Taixi (KI3). Эмчилгээний үр дүнд эм зүү хавсарсан бүлэг эмчилгээний үр дүн илүү байсан ба толгой эргэх, чих шуугих, чих дүүрэх, сонсгол буурах зовуурь мэдэгдэхүйц буурсан байсан нь бидний судалгааны үр дүнг нотолж байна^{6,7}.

Дүгнэлт, санал, зөвлөмж: Меньерийн өвчнийг эмчлэхэд өвчний дахилт хоорондын зайг уртасгах, амьдралын чанарыг дээшлүүлж, эмнэлзүйн шинж тэмдэг мэдэгдэхүйц буурсан нь Уламжлалт анагаах ухааны эм, засал эмчилгээ үр дүнтэй нь харагдаж байна.

Ном зүй:

1. Цагаанхүү Г. Дэлгэрмаа Ц. Мэдрэл судлал. Улаанбаатар. Адмон хэвлэлийн газар 2014. 278-279х
2. Min Hee Kim. *Chunhoo Cheon* Epidemiology and Seasonal Variation of Ménière's Disease: Data from a Population-Based Study. *Audiol Neurotol* (2020) 25 (4): 224–230.
3. <https://doi.org/10.1159/000506921>
<https://www.nidcd.nih.gov/health/menieres-disease>
4. Сээсрэгдорж С, Чимэддрагчаа Ч, Хишигжаргал С, Бусад Б. Монголын уламжлалт анагаах ухааны өвчнийг анагаах үндис. Улаанбаатар хот, 2021.
5. Анагаах ухааны 4 үндэс. Улаанбаатар хот. 1991 320х, 384х
6. *Mingjie Tang*. Yinghong Li. *Man Lu*. Tianchen Zhang. Yanhao GeJie Han. Jiqin Tang. Zhaoming Chen. Efficacy and safety of acupuncture in the treatment of Meniere's disease: a systematic review and meta-analysis <https://doi.org/10.3389/fmed.2024.1463821>
7. Gao Shu Zhong. Zhenjiu Zhiliao Xue. 2021. 42
8. Hermann Simo. Shiayin Yang. Weikai Qu. Michal Preis. Munier Nazzal. Reginald Baugh. Meniere's disease: importance of socioeconomic and environmental factors. DOI: [10.1016/j.amjoto.2015.01.009](https://doi.org/10.1016/j.amjoto.2015.01.009)

Treatment of miniere's disease (icd-10 h.81) using traditional medicine and therapeutic interventions: Case report

Undarmaa B¹, Tserendulam G², Oyun-Erdene U³, Oyunnyam Ch³, Nasankhishig D³, Khaliun E², Tsegmed G³, Oyunbileg Yu², Enkhtuya V²

¹ Central Hospital of Mongolian Medicine, MNUMS

²International School of Mongolian Medicine, MNUMS

³Professional Development Institute, MNUMS

E-mail: undarmaa.bayar@mnumns.edu.mn, Tel: +976-89118982

Keywords:

Dizziness, tinnitus, hearing loss, Mongolian traditional medicine, acupuncture

Background: Meniere's disease is a condition caused by disturbances in the auditory and vestibular systems. It is characterized by symptoms such as dizziness, nausea, vomiting, and tinnitus. In the United States, the prevalence of Meniere's disease has been found to be 84 cases per 100,000 women and 56 cases per 100,000 men. Regionally, it is more common in less populated areas, and research has confirmed that the prevalence increases with higher household income.

Aim: To evaluate the effectiveness of traditional medicine treatments and therapies for Meniere's disease.

Results: The patient is a 43-year-old male, with symptoms of dizziness, vomiting, and tinnitus. Since 2023, he has sought care at the Central Hospital of Mongolian Medicine, where he received traditional medicine treatments including herbal therapy and other traditional therapies on three occasions. As a result, the frequency of dizziness has decreased and other clinical symptoms have improved.

Conclusion: Traditional medicine treatments have been shown to be effective in managing Meniere's disease by extending the interval between relapses, improving quality of life, and significantly reducing clinical symptoms.